




ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА - 2022



УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАН, ТОХИОСОН:

Д.Мөнхзул

ЧДС-ийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГЫГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Б.Цогбаясгалан

ЧДС-ийн хэлтсийн мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,

Нийслэлийн Засаг захиргааны 3-р байр

Утас: 70130767, 70110767, 11-310767

И-мэйл: chingeltei@nso.mn

Цахим хаяг: www.ubstat.mn, chingeltei.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРГАН ТАНИЛЦУУЛГА.....	2
ОРШИЛ	3
ХАМРАХ ХҮРЭЭ	4
III. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	5 – 10
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	11 – 12
ДҮГНЭЛТ	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, сая төгрөг, 2018 – 2022 он

Хүснэгт 2. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, сая төгрөг, 2018 – 2022 он

Хүснэгт 3. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, сая төгрөг, 2018 – 2022 он

Хүснэгт 4. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, 2020 – 2022 он

ГРАФИК ЖАГСААЛТ

График 1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтын харьцаа, тэрбум төгрөг, 2018-2022 он

График 2. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, хувиар, 2018-2022 он


График 3. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, хувиар, 2018-2022 он




АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2022 оны жилийн эцсээр

Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/


Уул уурхайн олборлолт аж үйлдвэр /сая төгрөг/



Боловсруулах аж үйлдвэр /сая төгрөг/



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа /сая төгрөг/



ОРШИЛ

Аливаа улс орны хөгжлийн гол тулгуур нь аж үйлдвэрийн хөгжил байдаг. Аж үйлдвэрийн салбар нь төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн, өндөр бүтээмжтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, өрсөлдөх чадвар бүхий экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх салбар юм.

Манай дүүргийн аж үйлдвэрийн салбарт нүүрс, алт, боржин, шохойн чулуу, нарийн боов, бялуу, хүүхдийн тэжээл, архи, хийжүүлсэн цэвэр ус, рашаан, энерги дринк, хөнжил, гудас, матрас, оймс, цэргийн хувцас, бүх төрлийн мөрдөс, бүх төрлийн цэргийн малгай, ажлын хувцас, цамц, өмд, бээлий, савхин дээл, хүрэм, цүнх, хаяг, шошго, маягт, дэвтэр, ном, сонин, сэтгүүл, хуанли, бүх төрлийн үнэт цаас, гоо сайхны тос, тэслэх бодис, хаалга, цонх, блок, замаска, алтан ээмэг, бөгж, бусад эдлэл, монетон ээмэг, бөгж, хөшиг, бүх төрлийн чавхдаст хөгжим зэрэг 55 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж, борлуулагдаж байна.

Сүүлийн жилүүдэд төр засаг болон дүүргээс үйлдвэржилтийг дэмжсэн бодлого, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн, үүний үр дүнд дотоодын үйлдвэрлэж нэмэгдэж байгаа билээ.

ХАМРАХ ХҮРЭЭ

Аж үйлдвэрийн салбарын богино хугацааны (сарын) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-3.1)-т, урт хугацааны (жилийн) мэдээг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC-4.0)-ын дагуу уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа гэсэн 4 дэд салбарыг хамруулан авч үздэг.

Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцохдоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг үндсэн буюу үйлдвэрлэгчийн үнээр тооцдог бөгөөд бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өөрчлөлтийг мөн үнэлж тусгадаг. Нийт үйлдвэрлэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын хэмжээг хасаж, тайлант хугацаанд шинээр бий болсон нэмэгдэл өртгийн хэмжээг дэд салбаруудаар тооцож байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тайлан болон холбогдох захиргааны статистик мэдээлэл болно. Мэдээллийг сарын болон жилийн давтамжтайгаар цуглуулж, холбогдох тооцооллыг хийдэг.

Сарын давтамжтайгаар: “Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ”-ний маягтаар аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБуудын гүйцэтгэлийг биет хэмжээ, үнийн дүнгээр тухайн сарын болон жилийн өссөн дүнг цуглуулдаг. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг оны үнээр, бүтээгдэхүүний борлуулалтыг, үүнээс гадаад, дотоодын борлуулалт, нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний тухайн сард борлогдоогүй үлдэгдэл, ажиллагчдын тоо, ажилласан цаг зэрэг үзүүлэлтийг тооцдог.

Жилийн давтамжтайгаар: “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ”, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хураангуй мэдээ” гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

“Цахилгаан эрчим хүчний баланс”, “Дулааны эрчим хүчний баланс”, маягтаар цахилгаан, дулааны станцуудаас мэдээллийг цуглуулдаг бөгөөд үйлдвэрлэсэн болон импортоор авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, цахилгаан станцын дотоод хэрэглээ, түгээлтийн болон шугамын алдагдал, хуваарилалт зэрэг үзүүлэлтээр цахилгаан, дулааны эрчим хүч тэнцлийг байгуулдаг. Харин “Олборлосон нүүрсний баланс” маягтын дагуу нүүрс олборлолтын мэдээг нүүрсний уурхайгаас авч, нүүрсний тэнцлийг байгуулан олборлосон нүүрсний хэмжээ, экспорт, тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол, хэрэглээг биет хэмжээгээр тооцож байна.



III. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Чингэлтэй дүүргийн аж үйлдвэрийн салбарын аж ахуй нэгж байгууллагууд 2022 онд нийт 85.6 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 89.5 тэрбум төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оны эцэстэй харьцуулахад үйлдвэрлэлт (45.9%) хувиар, борлуулалт

(43.1%) хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, сая төгрөг, 2018-2022 он

Он	Нийт үйлдвэрлэл	Нийт борлуулалт
2018	104 274.7	112 112.8
2019	148 146.7	157 313.4
2020	364 621.9	213 078.8
2021	58 660.2	58 330.5
2022	85 566.1	89 469.3

ГРАФИК 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ХАРЬЦАА, тэрбум төгрөг, 2018-2022 он




Харин аж үйлдвэрийн 2022 оны нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт өмнөх онтой харьцуулахад нүүрс олборлолт ямар нэг өөрчлөлт байхгүй, Харин хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл (7.8%), болж өссөн байна. Харин нэхмэлийн үйлдвэрлэл (96%)иар буурсан байна.

ХҮСНЭГТ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, САЛБАРААР, сая төгрөг 2018 – 2022 он

Салбараар	Нийт үйлдвэрлэл				
	2018	2019	2020	2021	2022
НИЙТ ДҮН	104 274.67	148 146.69	364 621.91	58 660.25	85 566.04
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР	77 472.56	122 929.44	339 479.94	40 005.44	52,878.63
Нүүрс олборлолт	13 105.86	22 911.39	283 248.61	-	-
Төмрийн хүдэр олборлолт	64 331.39	99 852.41	35 845.86	15 733.65	26 283.02
Бусад ашигт малтмал олборлолт	35.30	165.64	20 385.47	24 271.80	26 595.61
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР	26 802.11	25 217.25	16 432.74	10 525.51	23 986.89
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ	5 132.87	5 407.36	5 320.76	18.33	5 717.22
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	620.46	604.25	224.95	-	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 059.81	4 437.66	4 784.21	-	-
Ундаа үйлдвэрлэл	452.60	365.45	311.60	18.33	5 717.22
Нэхмэлийн үйлдвэрлэл	4 716.03	6 444.71	201.21	3 475.32	7 522.87
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	6 028.38	3 782.49	5 224.73	3 298.85	5 313.53
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	575.35	504.32	440.76	-	-
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-	-	-	-	31.01
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	7 177.94	6 061.37	3 901.14	2 539.82	3 131.37
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	502.79	1 143.03	255.61	-	-
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	829.26	236.01	157.35	-	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	834.12	711.04	726.60	-	-
Үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс, холбогдох эдлэл үйлдвэрлэл	-	-	71.31	-	-
Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	-	-	-	-	1 145.09
Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	-	-	285.55	1 187.25	403.98
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	1 005.36	926.93	-	5.95	721.81
Дээр дурдсан ангид ороогүй боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	2.23	-	-
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	8 709.22	8 129.29	8 700.52
Хог хаягдлыг цуглуулах	-	-	8 709.22	8 129.29	8 700.52

Мөн аж үйлдвэрийн 2022 оны нийт бүтээгдэхүүний борлуулалт өмнөх онтой харьцуулахад (43.1%), уул уурхай олборлолт (32.2%), тус тус өсөж, Харин нэхмэлийн үйлдвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад (77.6%) – аар өссөн байна.

ГРАФИК 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, САЛБАРААР, хувиар, 2018-2022 он




ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, САЛБАРААР, сая төгрөг, 2018-2022 он

Салбараар	Нийт үйлдвэрлэл				
	2018	2019	2020	2021	2022
НИЙТ ДҮН	112,112.76	157,313.39	213,078.80	58,330.55	83,469.35
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР	77,539.19	122,896.84	182,925.76	40,005.44	52,878.63
Нүүрс олборлолт	13,135.99	22,911.39	126,819.44	-	-
Төмрийн хүдэр олборлолт	64,331.39	99,852.41	35,845.86	15,733.65	26,283.02
Бусад ашигт малтмал олборлолт	71.81	133.04	20,260.46	24,271.80	26,595.61
БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР	34,573.56	34,416.55	21,443.82	10,195.81	21,890.19
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ	5,608.05	5,440.43	5,309.15	69.52	5,717.22
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	1,104.33	596.45	224.95	-	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4,059.81	4,437.66	4,784.21	-	-
Ундаа үйлдвэрлэл	443.91	406.32	299.99	69.52	5,717.22
Нэхмэлийн үйлдвэрлэл	3,104.09	5,876.83	201.21	3,053.12	5,421.76
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	5,481.27	5,484.38	5,368.08	3,317.56	5,554.59
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	696.51	761.69	707.36	-	-
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-	-	-	-	43.07
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	7,177.94	6,061.37	3,901.14	2,564.39	3,131.37
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9,691.84	8,595.40	4,492.08	-	-
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	844.36	247.77	161.91	-	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	1,088.95	1,040.48	943.81	-	-

Үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс, холбогдох эдлэл үйлдвэрлэл	-	-	71.31	-	-
Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	-	-	-	-	965.78
Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	-	-	285.55	1,187.25	403.98
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	880.55	908.20	-	3.97	652.42
Дээр дурдсан ангид ороогүй боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	2.23	-	-
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГ ДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	8,709.22	8,129.29	8,700.52
Хог хаягдлыг цуглуулах	-	-	8,709.22	8,129.29	8,700.52

ГРАФИК 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, САЛБАРААР, хувиар, 2018-2022 он



Аж үйлдвэрийн салбарт 2018 оноос 2022 онд 37 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулсан байна. Үүнээс алт (58.4 кг)-аар өсөж, Харин аюулгүй хог хаягдлыг цуглуулах, нийлүүлэх, хадгалах, дахин боловсруулах үйлчилгээ (36.3 тн) – оор өсөж, Мөн бусад төрлийн ажлын оёмол хувцас 4.8 мянган ширхэгээр буурсан байна.

ХҮСНЭГТ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ, 2018-2022 он

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2020	2021
Аюулгүй хог хаягдлыг цуглуулах, нийлүүлэх, хадгалах, дахин боловсруулах үйлчилгээ	тн	117 370.4	153 694.8
Уран зураг, гэрэл зураг, толь ба адил төст эд зүйлийн модон жааз	ш	-	180.0
Цэвэршүүлээгүй алт	кг	111.3	169.8
Цэвэршүүлсэн мөнгө	кг	-	0.2
Үндсэн металлаар хийсэн дүүжилдэг болон ердийн цоож (түлхүүр, шифр, цахилгаан удирдлагаар онгойдог); үндсэн металлаар хийсэн цоож, түлхүүр, түүний эд анги; тавилга, хаалга, шат, цонх, эмээл, авдар, чемодан, хайрцаг сав, тэдгээртэй адил төстэй эд зүйлийн үндсэн металлаар хийсэн холбоос, бэхэлгээний эд анги; үндсэн металлаар хийсэн тавиур, дэгээ, өлгүүр болон хана, таазанд тогтоогч бэхэлгээ	ш	-	225.00
Албан тасалгааны зориулалттай модон ширээ	ш	-	40.0
Гал тогоо, гэр ахуйн зориулалттай, төмөр, ган бусад төрлийн эдлэл төмөр ган зэс, хөнгөн цагаанаар хийсэн зүлгэх өнгөлөх, цэвэрлэх зүлгүүр, бээлий, тэдгээртэй төстэй эдлэл	ш	-	190.0
Сүлжмэл урт, богино оймс, оймсны төрлийн эдлэл	мян.хос	986.4	1,884.5
Цагаан архи	мян.л	0.6	6.4
Буйдан, диван, бусад төрлийн зөөлөн ор	ш	-	1,006.0
Уул уурхайн бусад төрлийн туслах үйлчилгээ	мян.м3	24 271 795.3	26 595 611.7
Үслэг хувцас	ш	580.0	27.0
Бусад төрлийн оёмол хэрэглэл	ш	22.0	1.0
Бүх төрлийн мөрдөс	хос	1 782.0	2 412.0
Бүх төрлийн цэргийн малгай	ш	775.0	4 700.0
Зангиа, эрвээхэй зангиа, хүзүүний алчууран зангиа	ш	132.0	962.0
Савхи, хиймэл савхиар хийсэн хувцасны бусад хэрэглэл	ш	-	2.0
Цэргийн китель	ш	1 585.0	3 075.0
Цэргийн пельник	ш	6 123.0	11 741.0
Эмэгтэй хүний цамц	ш	2 675.0	6 509.0
Эрэгтэй хүний оёмол богино хүрэм, куртка, нөмрөг, юүдэнтэй хүрэм (цанын хүрэм орно)	ш	-	6 525.0
Бусад төрлийн ажлын оёмол хувцас	ш	8 562.0	3 758.0
Таван хурууны ба нэг хурууны оёмол бээлий, ханцуйвч	хос	2 235 000.0	1 779 200.0
Нэхий цамц, хантааз	ш	-	4.0
Эмэгтэй хүний оёмол өмд	ш	735.0	5 708.0
Эрэгтэй хүний сүлжмэл хүрэм	ш	-	7 745.0
Эрэгтэй хүний цамц	ш	3 950.0	3 200.0

Бусад төрлийн эсгий эдлэл	мян.ш	-	0.03
Хүүхдийн эсгий гутал	хос	161.0	602.0
Эсгий оймс, шаахай	ш	-	103.0
Чавхдаст бусад хөгжим	ш	4 748.0	2 506.0
Туузан болон жалюзан хуванцар хөшиг	ш	1 906.0	1 164.0
Хулдаасан хэвлэл	м2	123 133.5	109 899.9
Бусад төрлийн хэвлэмэл ном	мян.х.д.х	106.9	27.0
Хүснэгт маягт	мян.х.д.х	453.9	1 524.5
Диплом, гэрчилгээ зэрэг үнэт цаас	мян.ш	777.0	1 121.2
Соёолжоор бэлтгэсэн шар айраг	мян.л	-	830.6

I. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж үйлдвэрийн салбарын статистикт дараах ойлголт, тодорхойлолтыг ашигладаг.

Үүнд:

Ойлголт	Тодорхойлолт
<u>Нийт үйлдвэрлэл</u>	Тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.
<u>Завсрын хэрэглээ</u>	Үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.
<u>Нэмэгдэл өртөг</u>	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ. Нийт үйлдвэрлэлийн үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.
<u>Бүтээгдэхүүний борлуулалт</u>	Тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.
<u>Аж үйлдвэрийн борлуулалт</u>	Зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.
<u>Үндсэн үнэ</u>	Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.
<u>Үйлдвэрлэгчийн үнэ</u>	Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг бараа, үйлчилгээний татвар (нэмэгдсэн өртгийн татвараас бусад) болон тээвэр, худалдааны нэмэгдлүүдийг нэмж, татаасыг хасаж тооцсон үнийг хэлнэ.
<u>Зах зээлийн үнэ буюу худалдан авагчийн үнэ</u>	Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг хэлнэ.
<u>Бүтээгдэхүүн</u>	Үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бараа, үйлчилгээг хэлнэ.
<u>Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)</u>	Зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.
<u>Гол нэр төрлийн бүтээгдэхүүн</u>	Тайлант хугацаанд үйлдвэрлэсэн салбарын үйлдвэрлэлийг төлөөлөхүйц бүтээгдэхүүнийг хэлнэ.
<u>Ажиллагч</u>	Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Ажил эрхлэлттэй холбоотой ойлголт, тодорхойлолт нь хөдөлмөрийн статистикт ашигладаг ойлголт, тодорхойлолттой адил байна.

<u>Ажилласан цаг</u>	Тайлант хугацаанд ажиллагчид (цалин хөлстэй ажиллагч болон цалин хөлсгүй ажиллагч)-ийн ажилласан цагийг хэлнэ.
<u>Үйлдвэрлэлийн индекс</u>	Үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгасан биет хэмжээний өөрчлөлтийг илэрхийлэх индексийг хэлнэ.
<u>Улирлын нөлөөллийг арилгах</u>	Хугацааны цуваан дахь улирлын шинж чанартай нөлөөллийг арилгах статистик арга юм.
<u>Цахилгааны тэнцэл</u>	Үйлдвэрлэсэн, импортоор авсан цахилгаан эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Цахилгааны тэнцлийг биет хэмжээгээр тооцно. Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт
<u>Дулааны тэнцэл</u>	Үйлдвэрлэсэн, импортоор авсан дулааны эрчим хүчний нийлбэртэй тэнцүү байна. Дулааны тэнцлийг биет хэмжээ (мян.Гкал)-гээр тооцно. Үйлдвэрлэл + Импорт = Дотоод хэрэглээ + Түгээлт + Шугамын болон түгээлтийн алдагдал + Экспорт
<u>Нүүрсний тэнцэл</u>	Оны эхний үлдэгдэл, тухайн жилд олборлосон нүүрсний нийлбэртэй тэнцүү байна. Олборлосон нүүрсний тэнцлийг биет хэмжээгээр тооцно. Оны эхний үлдэгдэл + Олборлолт = Борлуулалт + Дахин боловсруулах үйлдвэрт өгсөн нүүрс + Экспорт + Тээвэрлэх, хадгалах үеийн хорогдол + Оны эцсийн үлдэгдэл

ДҮГНЭЛТ

Чингэлтэй дүүргийн аж үйлдвэрийн салбар нь 2022 онд төрийн болон хувийн хэвшлийн 1 282 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс 418 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж үүнээс түүврийн аргаар 54 аж ахуйн нэгжээс аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээг АҮ-1 маягтын дагуу авсан тооцоон дээр нийт 85.6 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 83.5 тэрбум төгрөгний борлуулалт хийсэн байна. Өмнөх оны эцэстэй харьцуулахад үйлдвэрлэлт 45.9 хувиар, борлуулалт 43.1 хувиар тус тус өссөн байна.



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Хайх ...




СТАТИСТИКИЙН

мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



/StatisticMGL

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn